PROCEEDINGS

of

the 10th Seoul International Altaistic Conference

Reexaminations of objects and methods of research into Altaic languages and cultures

Grand Conference Hall, 70th Anniversary Memorial Bldg.,

Sunchon National University, KOREA

14~17 July, 2011

The Altaic Society of Korea

МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООНЫ ҮГИЙН САНГИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙ АСУУДАЛД

Академич Л.Болд

"Монголын нууц товчоо (хойшид МНТ гэнэ Л.Б)" нь түүхэн үйл явдлыг уран сайхны аргаар дүрслэн үзүүлэхдээ тухайн үеийнхээ монгол хэлний үгийн санг чадамгай ашигласан байдаг. Гагцхүү монголчуудын уламжлалт ёс заншил, ертөнцийг үзэх үзэл, ахуй соёлын өөрчлөлтөөс шалтгаалж зарим үг хэллэгийн анхны утга нь эртнийхээ шинжийг хадгалсан зүйр цэцэн үг болон төрөл хэлний үгийн санд хадгалагдаж үлдсэн байх жишээтэй. Үүнийг бид тодорхой жишээн дээр тулгуурлан авч үзье.

МНТ-ны §246-р зүйлд буй **"manaqar(u) ügüleksen-i üdeši hudaru'asu üde-yin ügüleksen-i manaqar hudaru'asu hičere maqa ke'ekdegü ele urida üge baraqdalu'a je teli ke'en soyurqaju jiči jaliraba"** гэсэн хэсэг дээр бага зэрэг ажиглалт хийж үзье.

Нэрт эрдэмтэн Б.Я.Владимирцовын зүйтэй тэмдэглэсэн ёсоор бол "... утга зохиолын үүднээс боловсруулагдсан ... тал нутгийн туульсын зохиолын хамгийн сонирхолтой жишээ (Владимирцов Б.Я., 1920.с.94)" болсон энэ зохиолыг аль тэртээ Мин улсын үеэс эхлэн янз бүрийн

тогтолцоотой бичиг[1], үсгээр буулгаж, мөн олон хэлээр орчуулсан эрдэмтэд үүн доторх үг хэллэгийг янз бүрээр ухаарсан байх юм. Академич Д.Цэрэнсодном гуайн баталж буйгаар бол тухайн зүйлд гарах **hudara'asu** гэдэг үгийг *'тайлбарлан задлах'* гэсэн утгатай үг, **je teli** гэдгийг *'тэр учир болно'*, **jaliraba**-г *'уур тайтгарав'* гэж хятад хадмал орчуулга хийгчид ухаарсан байна (Цэрэнсодном Д., 2000, х.341).

Харин Лувсанданзан, Гаадамба Ш, Элдэнтэй Артажав зэрэг харьцангуй хожуу үеийн эрдэмтэд бидний сонирхож буй хэсгийг уйгаржин монгол үсгээр сэргээн тэнхрүүлэх аргад тулгуурлан авч үзэхдээ уг эхийг ихэд баримтлахыг хичээхийн гадна, ялангуяа сүүлийн үед уг зохиолд гарах эртний монгол хэлний зарим үгэнд зохих тайлбар хийснийг дурдах хэрэгтэй. Тухайлбал эрдэмтэн Ш.Гаадамба энд өгүүлэгдэх **жалираба** *'уур нь намдаж царай нь засрав'* гэдэг үгийг *"...монгол хэлний жали гэдэг галын дөлийн нэрнээс 'цог заль, суу заль' гэх мэт цог жавхлан нүүрэнд баяр хөөр цог золбоо гэрэлтэн илэрхийг тэмдэглэдэг монгол үг гэж бодож байна"* (Гаадамба Ш., 1990. х.397) гэж үзсэнээ тэмдэглэсэн нь бий. Бусад үгэнд нь тайлбар хийсэнгүй. Харин Элдэнтэй, Артажав нар өөрсдийн хийсэн сийрүүлэгтээ нэлээд тайлбар дагалдуулжээ. МНТ-ны үгсийн сангийн бүрэлдэхүүнийг тодруулах зорилго тавьж буй бидэнд энэ нь сонирхолтой байна. Тухайлбал **udarubas** гэдгийг *'урах'*, *'цуулах'*, *'задлах'*, *'нээх'*, *'эвдлэх'* гэсэн утгатай үг гэж үүнээ "Таван хэлний толь", "Хорин нэгтийн тайлбар толь" зэрэг түүхэн толь бичиг, мөн Альшаа аман аялгууны хэрэглэгдэхүүн зэргээр баталгаажуулжээ. Мөн **ičar-a** *'ичих, ичгүүр'*, **teli** гэдгийг буриад аялгууны *'тийм үү, ингэж,*

1 МНТ-г хятад үсгээр хятад орчуулгыг чухам хэдийд хийсэн тухай доорх зохиолоос дэлгэрүүлэн үзнэ үү. Үз. Д.Цэрэнсодном "Монголын нууц товчоо", Уб., 2000, х.9-28.

тийм болбол, тэгвэл' гэсэн утгатай үг, **jali-r(a)-ba** гэдэг үгийн язгуур "... түрэг хэлний **jalin** мөн" гээд *'1. дөл (галын), 2. цахилгаан, аянга'* гэсэн утгатай болно гэх мэт тайлбар хийсэн байна (Элдэнтэй, Артажав, 1986, х.56).

Харин МНТ-ны эхийг крил үсгээр сэргээсэн эрдэмтэд бидний сонирхож буй эхийг

"...Өглөө өгүүлснийг
Үдэш задалбаас
Үдийн өгүүлснийг
Өглөө задалбаас магад ичгүүр хэмээгдэх эл (гэж) *урьд үг баригдлаа зээ тэр"* (Цэрэнсодном Д., 2000, х.341) гэх буюу зарим судлаачид уул эхийг баримтлан

"... Манагар өгүүлснийг
Үдэш ударбаас
Үдшийн өгүүлснийг
Манагар ударбаас
Ичир мага хэмээгдэх л. Урьд үг барагдлаа. Зэ тели хэмээн соёрхож, жич залирав"

гэж сэргээсэн байна. Үүний эхний тайлбарыг академич Д.Цэрэнсодном хийсэн бөгөөд энд өгүүлэгдэж буй *задалбаас, зэ тэр, тайтгарав* гэсэн гурван үгэнд нь тайлбар хийсэн байна. Тухайлбал, **(х)удару'ас** гэдэг үгийг монгол бичгийн хэлний **ударху** *'задлах, урагдах'* гэдэгтэй язгуур нэгтэй гэж үзсэн ахул, **жэ тэли** гэдгийг *'за, тэгье, ингэе'* гэсэн утгатай, харин **'жалираба'** МАА тольд буй **жали** *'амар тайван'* гэдэг үгтэй холбон үзжээ (Цэрэнсодном Д., 2000, х.341). Энд эшилсэн хоёрдахь орчуулгыг хийсэн эрдэмтэн Ш.Чоймаа хийж, түүндээ доорх тайлбарыг дагалдуулжээ. Үүнд:

Манагар-*өглөө*
Ударбаас-*цуцалбаас*

Ичир магад-*магад ичгүүр, ичгүүр магад*

Тэли-*тийм, зөв буй*

Залирав-*тайтгарав* (Цэрэнсодном Д., 2000, х.341) гэсэн утгатай гэж тайлбарлажээ.

Харин МНТ-г орчин цагийн монгол хэлэнд орчуулсан академич Ц.Дамдинсүрэн гуай бидний сонирхож буй өгүүлбэрийг *...Минлиг эцгийг буруушаан донгодоод жич. "Өглөө хэлснээ үзэш няцаж, үдэш хэлснээ өглөө няцаж явбал ичгүүртэй биш үү. Урьд хэлснээ хатуу барьж явбал дээр биш үү" гээд бас зарлиг болруун* (Дамдинсүрэн Ц., 1990, §246) гэжээ.

МНТ-ноос авсан дээрх өгүүлбэрийг худам монгол бичиг болон орчин цагийн монгол хэлээр буулгасан эрдэмтдийн хийсэн орчуулга, зарим үгийн утгын тайлбар зэргээс үзвэл **hudary'asu** гэсэн үг бидний анхаарлыг зүй ёсоор татаж байна. Олонх судлаачид энэ үгийн утгыг *'тайлбарлаж задлах'* (хятад хадмал орчуулга хийгчид), *'задлах, урагдах'* (Д.Цэрэнсодном), *'няцах'* (Ц.Дамдинсүрэн), *'цуцалбаас'* (Ш.Чоймаа), *'урах, цуулах, задлах'* (Элдэнтэй, Артажав) утга илэрхийлж байна гэж тус тус үзжээ.

Гэвч энэ үг өмнөх эрдэмтдийн тайлбараас арай л өөр утга илэрхийлж байх шиг байна. Энэ учирлалаа доорх хэдэн баримтад түшиглэн өгүүлье.

Монгол аман зохиолд:

Өглөө өгүүлснээ үдэд мартах

Үдэд өгүүлснээ үдэш мартах (Дашдорж Ж., Ринченсамбуу Г. 2008, х.223) гэсэн зүйр цэцэн үг байдаг бөгөөд энэ нь бидний бодоход МНТ-нд буй

Манагар өгүүлснийг

Үдэш ударбаас

Үдшийн өгүүлснийг

Манагар ударбаас гэдэг хэллэгтэй утгын хувьд таарахаас гадна, ер нь нэг л цэцэн үгийн хувилбар гэж үзэхэд зүй ёсоор хүргэж байна. Хэрэв бидний хэлж буй энэ зүйл алдаагүй болох аваас МНТ-нд буй **hudaru'asu** гэдэг үг нь ерөөсөө *'мартваас'* буюу *'мартах~умартах'* гэдэг утга илэрхийлсэн байж болох юм. Ингэж үзэх нь даруй монгол хэлтэй төрөл хэл болох түрэг хэл, тэр дундаа монгол хэлний олон үгийн эртний хэлбэрийг хадгалсан хэлнүүдэд энэ үг яг ийм хэлбэр, утгатай тохиолдож байгаа явдал юм. Тухайлбал, **унтандурар** *'мартагнах, мартуулах'*, **унттур** *'мартах, орхих, болих'* (ТувРС.М.1968, с.441) гэсэн үг тува-орос тольд тэмдэглэгдсэн байх бөгөөд уг толийг хийгчид эдгээр үйл үгийг **ут-** *'март-?'* гэдэг үйл үгийн үйлдэгдэх хэвд байгаа хэлбэр гэж тайлбарлаж байна. Түрэг хэлнүүдийн харьцуулсан толь зэрэг судалгааны бүтээлээс үзвэл уул үгийн бичигт тэмдэглэгдсэн харьцангуй эртний хэлбэр нь **unit-~unut-** (ДТС.с.612) бөгөөд орчин цагийн түрэг хэлнүүдэд хоёр эгшгийн дунд орсон **-n-** гийгүүлэгчээ хадгалсан хэлбэрээр олонх түрэг хэл аялгуунд тохиолдож байна. Үүнд: азерб, **унут-**, тур, **unut-** *'мартах, өршөөх'*, **unutkan** *'мартамхай, мартамтгай'*, **unutulmak** *'мартагдах'* (Турк-монгол толь, Уб., 2006, х.340-341), кирг. **унут** *'забвение, забытость'*, **унут-** *'забывать'*, **унуткор** *'забывчивость'* (КирРС. 1985, с.305), каз. **умыт-у** *'мартах'*, **умытжак** *'мартамхай, мартамтгай'*, **умытыл-у** *'мартагдах'* (Базылхан Б., 1977, х.329). Үгийн гарлын зүйн үүднээс авч үзвэл түрэг хэлнүүдийн **унут-~умыт-** хэлбэрийг монгол хэлний **umarta-** гэдэгтэй холбон үзэх бололцоо байж болох мэт санагдана. Гэхдээ бид уг асуудалд анхаарлаа хандуулахаа түр азнаад МНТ-нд буй уг үгийн утгыг авч үзэхэд илүү чухал гэж үзэж байгаагаа дурдсу.

МНТ-ны үгийн санг анхааралтай үзвэл **hudaru'asu** гэдэг үг §255-р зүйлд бас тохиолдож байна. Үүнийг сийрүүлбэл: **"min-u jarliq busu ülü bolqan ese bolqan ese hutaru'asu ülü endekün ülü aldaqun ta"** гэж буйг *"... миний зарлигийг өөрчлөхгүй, **задлахгүй**, осолдохгүй,*

алдахгүй баримталж явтугай" (Ц.Дамдинсүрэн), **"minu jarliγ busu ülü bolqan ese udarbasu ülü endekün ülü aldaqun ta"** (Ш.Гаадамба, Элдэнтэй, Артажав), *"...миний зарлигийг үл өөрчлөн эс задалбаас үл эндэн үл алдана та нар"* (Д.Цэрэнсодном), *"...миний зарлиг бус үл болгон эс ударбаас үл эндэхүүн үл алдахун та (та нар)"* (Ш.Чоймаа, 2011) гэж сэргээн үзсэн байна. Эдгээр сийрүүлгэ хөрвүүлгээс үзвэл **udarubasu** гэдэг үгийг судлаачид өмнөх зүйлд дурдсан уул үгийг ямар утгатай гэж үзсэн тэр ёсоор ухаарч байгаа нь тодорхой байна. Гэвч энэ удаад бидний сонирхож байгаа үгтэй МНТ-оос эшлэл авсан хоёрдахь өгүүлбэрт гарч буй **hudaru'asu** гэдэг үг утгын хувьд *'мартах~умартах'* гэдэг утга илэрхийлж буй нь бүр ч тодорхой ажиглагдаж буйг анхаарахгүй өнгөрч болохгүй мэт. Өөрөөр хэлбэл, *"Миний зарлигийг бус үл болгон, эс мартваас үл эндэх, үл алдах (билээ) та нар"* гэж Чингис хаан үр хойчостоо зарлиг болгожээ гэж дээрх өгүүлбэрийн утгыг тоймлон буулгаж болох юм.

МНТ-ны үгийн санд **umartaqu** *'мартах'*, **umartaqdaqu** *'мартагдах'* гэдэг үг байгаа учир бидний тавьж буй учирлал зарим нөхцөлд эргэлзээтэй мэт санагдаж болох юм. Гэвч, бидний үзэхээр энэ хоёр үгийг хэрэглэсэн нөхцөл байдал, уул үгсийн найруулгын өнгө аяс ихээхэн ялгаатай байна.

Тухайлбал **umartaq** *'мартах'* гэдэг үгийг МНТ-нд мөн л хоёрхон удаа хэрэглэсэн бөгөөд үүний нэгдэхийг нь Жамух, Тэмүүжин (Чингис хаан)-д олзлогдон ирснийхээ дараа "эрт өдөр өчүүхэн цагт Хорхоног жабур (-ын хөндийд Ц.Д)-д анд лугаа

"...ülü šinggeküi ide'e ideldü-jü

ülü umarta-qu üges ülelde-jü ..." §201 *(Үл шингэх идээ идэлцэж үл мартах үгээ хэлэлдэж)* явснаа дурсан өгүүлэхдээ уул үгийг хэрэглэсэн байна. Мөн Тэмүүжин (Чингис хаан) өөрт тустай явсан хүмүүсээ дурсан ач гавьяаг үнэлэхдээ, Мэнлиг эцэгт хандан

"...tere tusa-yi sayi setki-jü
urq-un uruq-a gürtele ker umartaqdaqu..." §204 *(Таны тусыг ургийг ураг хүртэл яахан мартах билээ)* гэж өгүүлж байна.

Гэтэл hudara'asu гэдэг үгийг ямар нөхцөлд хэлсэн бэ? гэдэг асуудал зүй ёсоор гарч ирнэ. Үүнд: Мэнлиг эцгийн долоон хөвгүүдийн дундах нь болох Хөхөчү буюу олонд алдаршсан монгол нэрээрээ бол Тэв тэнгэрт "есөн хэлтэн" улс хуралдан очиход тэдний дотор Чингис хааны агтны хорооны олон хүн, бас Отчигин, Тэмүгэгийн харьяат иргэд ч оролцжээ. Иймд Отчигин ноён Тэв тэнгэрийг даган одсон иргэдээ буцаан ирүүлэхээр Сохор нэрт элчийг илгээсэн боловч Тэв тэнгэр түүнийг нь зодож эмээлийг нь үүрүүлэн элчийг явган буцаажээ. Үүний дараа Отчигин ноён харьяат иргэдээ авахаар өөрийн биеэр очиход Мэнлиг эцгийн долоон хөвгүүд Отчигин ноёныг зодохыг завдсанд тэр "Элч илгээсэн минь буруу болжээ" гэж хэлүүлээд зогссонгүй Тэв тэнгэрийн хойноос наминчлан мөргүүлжээ. Маргааш нь Тэмүжин ахдаа энэ байдлаа хэлэхээр очиход, Бөртэ үжин хөнжлийн сэжүүрээр өвчүүгээ дарж "Тэд хонхтон нар яасан хэцүү улс билээ. Урьд Хасарыг бүслэн занчсан, одоо бас энэ Отчигинийг хойноосоо сөгдүүлэв"

"...Үүнээс хойш тэд
Үүл мэт биеийг чинь
Үгүй болж одвол
Үлдсэн их улсыг чинь
Үр хүүхдээр чинь мэдүүлэх үү?...
Өндөр уулын нарс мэт
Өнөр сайхан дүү нарыг чинь
Өшин дарлагч тэд
Өсөж бойжиж амжаагүй
Өчүүхэн хэдэн хүүхдэд чинь
Өргөн их улсыг мэдүүлэх үү?..."

гэж нулимс урсган өгүүлэхийг сонсоод Чингис хаан Отчигинд "Тэв тэнгэр одоо ирнэ өшөөгөө яаж авахыг чи өөрөө мэд" гэжээ. Нэгэнт ахын үгэнд хорслоо тайлах аятай далим гарсан учир гурван бөхийг урьдаас бэлдэн түүнийг ирэхэд гэрээс чирэн гарч, тэр бөхчүүдээр нурууг нь хугалуулаад гэрийн зүүн талд буй угсарсан тэрэгний орчимд орхижээ. Чингис хаан түүнийг нь үзэж хойдуулаас нэгэн бор гэрийг авчруулж Тэв тэнгэрийн дээр бариулаад тэндээс нүүжээ. Гурав хоносны дараа эргэн ирж үзвэл өрхийг бүтээж үүдийг нь хаан тусгай хүнээр сахиулсан атал Тэв тэнгэрийн хүүр үгүй байв. Үүнийг нь *"Тэв тэнгэр ёс бус зан гаргасан учир түүний амь биеийг тэнгэр авч одов"* хэмээн *"өөрсдийн буруу үйлдлээс болж Тэв тэнгэрийг алдав"* хэмээн Мэнлиг эцэгт өгүүлээд дээрх үгийг хэлсэн байна.

Есүхэй баатрын гэрээслэл ёсоор **"üčüget qočoruqsan de'ü-ner-iyen belbesün bergen-iyen asaraqu"** (§68) үүргийг хүлээсэн Мэнлиг эцэг түүний үр хүүхдийн гаргасан авир аашийг буруушааж хэлсэн доорх үгийн дотор буюу МНТ-ны §246-р зүйлийн дотор **urida üge bar baraqdulu'a je teli** гэдэг үг бас зүй ёсоор анхаарал татаж байна.

urida üge bar baraqdulu'a гэдгийг олонх судлаачид уг эхэд буйгаар зөв буулгасан (Лувсанданзан, Чоймаа Ш.) авч бас зарим нь **barildulu**γ**-a** буюу баригдлаа (Гаадамба Ш, Цэрэнсодном Д.) гэж буулгасан үзэгдэнэ. Бидний бодоход эхний хувилбар нь зөв байх. Учир нь **urida üge** гэдэг нь **qa'učin üge** *'хуучин үг'*, **ötögus üge** *'өтгөсийн үг'* (§78) гэдэгтэй адил үр хүүхдээ сурган хүмүүжүүлэхэд хэрэглэдэг зүйр цэцэн үг шиг сургамжтай үг гэж ухаарч байна. Тийм ч учраас Чингис Мэнлиг эцэгтээ энэ үгийг дурдан сануулж соёрхож сургасан байж болох юм. Өөрөөр хэлбэл, урьдын (зүйр цэцэн) үгийг Та нар мартлаа (барагдлаа) тийм үү?! гэсэн санаа байж болох юм. Хэрэв бидний энэ таамаглал үнэн бол **hudaru'as** гэдэг үг тухайн үеийн хүмүүсийн ярианы хэл (ө.х. Жамух г.м.) ярианд биш харин зүйр цэцэн

үг мэт **urida üge**-нд хадгалагдан үлдсэн байжээ гэж дүгнэж болмоор байна.

Энэ мэтээр түрэг хэлнүүдэд эх утга нь хадгалагдан үлдсэн үгийн тоонд zemlen гэдэг зүй ёсоор орж байна. Энэ үг МНТ-ны §214-р зүйлд тохиолдоно. Үүнийг сийрүүлбэл

ger-ün ümere ietei zelme qoyar muqular qara hüker jelmen alaju büküi-tür ...гэсэн өгүүлбэр байна. Академич Дамдинсүрэн гуайн хийсэн дээрх орчуулгад бидний сонирхож буй **...jemlen alaju...** гэсэн үгийг *'нядалж'* гэдэг үгээр буулгасан нь ерөөс зохиогчийн өмнөө тавьсан зорилготой нь өөрөөр хэлбэл, орчин цагийн уншигчдад уул бүтээлийг ойлгомжтой байхын зэрэгцээ бас тэр зохиолын уран сайхныг хадгалах гэсэн үзэлтэй нь шууд холбоотой байх. Академич Д.Цэрэнсодном бидний сонирхож буй **зэлмэн** гэдэг үгийн талаар хийсэн тэмдэглэлдээ энэ үгийн *"...дуудлага зөвтэй бөгөөс энэ нь зэмсгээр алах буюу мэслэн алах гэсэн утгатай үг байж болох юм"* (Цэрэнсодном. 2000. х.329) гэжээ. Хятад үсгийн галигийг буулгасан эрдэмтэд **zelmen** гэж буулгасантай ижил язгуурт үгийг эрэн зэмсэг гэдэг үгийг нэг язгууртай гэж ухаарч байгаа учир зохиогч уул үгтэй ойролцоо утга бүхий мэс гэдэг үгээр орчуулсан байна. Харин Ш.Гаадамба энэ үгийг *'...telen alaju...'* гэж Ш.Чоймаа *'зэмлэн (төхөөрөн) алж...'* гэжээ. Энэ бүхнээс эргэцүүлэн үзвэл дээрх тайлбарууд нь үхрийг яаж алах арга ажиллагаатай холбон үзсэн нь бас л эргэлзээтэй санагдаж байна. Иймд хятад орчуулгыг харгалзан үзвэл идэх гэсэн утгатай **ji** язгуурт төрөл үгийн хүрээнд эрэл хийж үзвэл уул үгийн утгыг тодруулж болох мэт санагдана. Ийм язгуураас бүтсэн *'идэх'* гэсэн утгатай үг бол орхон бичгийн дурсгалд тохиолдож буй **ji** *'ид-'* гэдэг үг гарцаагүй мөн. Энэ үг яг энэ утга хэлбэрээрээ манай улсын нутагт буй орхон бичгийн дурсгалуудаас Тоньюкукийн гэрэлт хөшөөнд тохиолдож байна. **köyik yiyü tabisγan yiyü olurun ertemiz bodun boγzi toq erti** (Т.8) *'(тэнд бид) зээр идэж, чандага идэж амар суух бөлгөө. Иргэд(ий минь)*

хэвлий (үгч. хоолой) цатгалан (үгч. дүүрэн) байв'. Харин уул үг эртний түрэг хэлэнд **y**, монгол хэлэнд **j** буй нь уул хоёр хэлний тухайн гийгүүлэгчдийн сэлгээгээр тайлбарлагдах зүйл юм. Энэ үг орчин цагийн бараг бүх түрэг хэлэнд өргөн хэрэглэгдэж байна. этх. **je-***'ид-'*, алт. **ji** *'ид-, хайрч болго-'*, як, сиэ, хак, тув. **či** *'ид-'*, каз. кирг. же-, туркм. ий- *'ид'*, уйг. йе, үзб. е- *'ид-, зоогло-'* (Рассадин В.И., 1971. с.106) гэх мэт. Үйл үг **je-** нь мөн тухайн үйлд хэрэглэгдэх зүйлийн нэр үүсгэдэг **-m** дагавар авч *'идэхэд хэрэглэгдэх юм, идэх юм~идддэг юм'* гэсэн утга илэрхийлсэн үг үүсгэдэг. уйг. йем, кирг. жем. тат. жим, каз. ккал. жем, тув. чем, як. сем *'идэх юм'* гэх мэт. Мөн **миш** гэсэн дагавар авч үйлд хэрэглэгдэх зүйлийн нэр үүсгэнэ. туркм. азб. уйг. йемиш, кирг. жемиш, ккал. жемис, тув. чемиш // монг. **jimis** *'жимс'*, бур. **zemehen** < ***jemüsün.** Нэрт түрэг судлаач Э.В.Севортян уул үгийн хэлбэрийг бас **ий, ij** гэж сэргээсэн (1974. с.333) нь үнэн байдалд нийцтэй болсон бол энэ үг бас монгол хэлний ид (мбх. **ide-)** *'амьтны юмыг хоол болгон хэрэглэх'* (Цэвэл. 1966. х.300) гэдэг үгтэй холбогдох нь тодорхой юм. Энд дурдсан баримтуудаас үзвэл МНТ-нд тохиолдож байгаа **jem(e)len** гэдэг үг нь **je-m-le-n** гэсэн дөрвөн бүтээврээс үүсэн үүсмэл үг бөгөөд үүний **je-** гэдэг язгуур нь *'ид-'* гэсэн утгатай, **jem** нь *'идддэг (юм), идэш'* гэсэн утгатай нэр үг болж байна. Энэ хэлбэрээрээ энэ үг **jem ičim** *'идэж уух юм'* гэсэн утгатай хоршоо үгийн хэлбэрээр эртний түрэг хэлэнд тохиолдож байна (ДТС. с.255). Мөн орчин цагийн нэлээд түрэг хэлнүүдэд уул үгийн хэлбэр буйг өмнө тэмдэглэсэн бөгөөд харин МНТ зэрэг монгол хэлний баримтад үгүй байна. Түрэг хэлнүүд дотроос монгол хэлтэй хамгийн ойр гэх тува хэлэнд уул үг өргөн хэрэглэгдэж байна. Чем чиир *'идэш (идэх юм), идэх'*, мал чеми *'малын тэжээл'*, быштак- чем *'боловсрох, идээ татах'* (ТРС. с.526). Гэвч ийм үг монгол хэлнүүдэд нэгэн цагт хэрэглэгдэж байсан, үүний тодорхой баримт бол МНТ-д ганцхан удаа тохиолдож байгаа **zem(e)len** гэдэг үг өөрөө байна. Иймээс энэ үгийг тэлэн алж, мэслэн алж гэх мэт

орчуулгуудын аль нь ч төдий л оносон хэрэг биш, харин хажуугийн хятад орчуулгыг баримтлан *'идшэнд алж буюу идшэнд (хэрэглэхээр) алж байхад'* гэвэл үнэн байдалд арай илүү ойртох мэт санагдана.

Энэ мэт өөрчлөлт нь үгийн сангийн улиран хувьсах үл улиран хувьсах зүй тогтолтой гүн холбоотой байдаг нь зүй ёсны бөгөөд бид энэ зүй тогтлыг зөвөөр ухаарч, сэргээн тэнхрүүлэх арга (рекньетруция)-д суурилан "МНТ"-ны үг хэллэгийн зөвхөн хэлбэрийг биш, бас утгыг авч үзэх нь юуны өмнө МНТ-ныхоо эхийг зөв сэргээн ухаарах, улмаар тухайн үеийн утга зохиолынхоо хэлний үгийн санг үүсвэр бүрэлдэхүүнийг зөв тодорхойлж чадах юм.

НОМ ЗҮЙ

Базылхан Базылхан Б., -*"Казак монгол толь"*, Редактор Ж.Ахмет, Б.Батаа Уб., 1977.

Владимирцов Владимирцов Б.Я., -*"Монгольская литература"* сб. "Литература Восток", вын II. Петрград., 1920.

Гаадамба Гаадамба Ш., -*"Монголын нууц товчоо судлалын зарим асуудал"*, Уб.,1990.

Гантогтох Гантогтох Г., -"Буриад аялгууны толь", Уб., 2010 (2011).

Дамдинсүрэн Дамдинсүрэн Ц., - *"Монголын нууц товчоо"* (хуучин монгол хэлнээс одоогийн монгол хэлэнд буулгав), УБ., 2008.

Дашдорж, Ренчинсамбуу Дашдорж Ж., Ренчинсамбуу Г., -*"Монгол ардын зүйр цэцэн үг"*, Уб., 2008.

ДТС *"Древнетюркский словарь"*, Л., 1969.

КиргРС -*"Киргизско-русский словарь II"*, М., 1985.

МХТТТ Цэвэл Я., -*"Монгол хэлний товч тайлбар толь"* УБ., 1966

Рассадин Рассадин В.И., -*"Фонетика и лексика тофларского языка"*, Улан-Удэ., 1971

Севортян Севортян Э.В., -*"Этимологический словарь тюркских языков"*, М., 1974.

ТМТ -*"Түрк монгол толь"*, УБ., 2006.

Цэрэнсодном Цэрэнсодном Д., -*"Монголын нууц товчоо"* /эрдэм шинжилгээний орчуулга, тайлбар/, Редактор. Д.Төмөртогоо, Уб., 2000

Чоймаа Чоймаа Ш., -*"Монголын нууц товчоо"* (эртний үг хэллэгийн түгээмэл тайлбартай шинэ хөрвүүлгэ), Редактор Д.Төмөртогоо, Уб., 2011.

Eldentei, Artajav -*"Mongγol-un niγuča tobčiyan-seyiregülel tayilburi"*, Köke qotu., 1986

MIDDLE ANCIENT MONGOLIAN TO BE CONNECTED WITH ANCIENT TURKISH

(By examples of "The Secret History of Mongols")

Academician Bold.L /Mongolia/

The author emphasized that the issues on how Mongolian languages are historically and etymologically connected with ancient and modern Turkish languages has drawn domestic and foreign scientists' attention and he has noted that researchers of Altaic studies has not come to terms on that issues based on latest researches. The author also mentioned that he has collected a few materials about issues on how middle Mongolian to be connected to ancient Turkish in order to make contribution to solve the problems. He has taken importance of the language of "The Secret History of Mongols" by representing Middle ancient Mongolian monuments. As a result of analyzing certain documents the author has made the following conclusions;

Even though a few words and expressions of "The Secret History of Mongols" were inherited to modern Mongolian for language evolution, there are many mysterious words that should be explained differently according to a famous scientist Sh. Gaadamba.

The author has concluded that diagnosing the meaning and structure of those "mysterious words" by researching their etymology and meaning within certain language family can give result to understand that source monument and moreover to study historic vocabulary of Mongolian language and historic relationship of Turkish and Mongolian languages intensively.